

ЗХА -ИЙН БҮС НУТГИЙН ИНТЕГРАЦИЙН АСУУДАЛД

*МУИС, ОУХС-ийн дэд профессор,
доктор (Ph.D) С.Отгонбаатар*

Зүүн Хойд Азийн эдийн засгийн хүрээ одоогоос 10-аад жилийн өмнөөс эхлэн тогтсон гэж үздэг. Бүс нутгийн орнуудын худалдаа хөрөнгө оруулалт жилээс жилд өсөн нэмэгдэж харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлж байгаа нь ЗХА гэдэг нэр томьёо зөвхөн газар зүйн ойлголт байхаа больсныг харуулж байна.

ЗХА-ийн бүс нутагт Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Монгол, БНАСАУ-уудыг хамруулан авч үзэх боловч сүүлийн үед Америк, Канад зэрэг Номхон далайн умард хэсэгт орших улс гүрнүүдийг хамруулж тэдгээр орнуудын бүс нутагт гүйцэтгэх үүрэг ролийг чухалчлан үзэх болов. Энэ бүс нутагт цөмийн зэвсэгтэй хэт их гүрнүүд, аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй ба жижиг буурай орнууд зэрэгцэн оршиж байгаа нь онцлог юм.

Энэ нь бүс нутгийн хөгжлийн ирээдүй, эдийн засгийн хамтын ажиллагаанд эдгээр орнуудын харилцааны онцлог чухал нөлөөтэй болохыг харуулж байна.

Өнөөдөртөө энэ бүс нутагт үндсэндээ хоёр талын хамтын ажиллагаа зонхилж байгаа ч бүс нутгийн хүрээнд зам харилцааны нэгдсэн сүлжээ байгуулах, худалдааг дэмжих зорилгоор нээлттэй бүс байгуулах, хамтарсан үйлдвэр, эрчим хүч, нефть, хийн шугам байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг чиглэлээр олон улсын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх алхмууд хийгдэж байгаа нь бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны эхлэл болж байна.

Бүс нутгийн орнуудын өсөн нэмэгдэж байгаа нефть, хийн хэрэгцээг хангах судалгаан дээр үндэслэгдэн яригдаж байгаа Хойд Сахалин, Саха, Иркутск болон Туркменистаны байгалийн хийн ордуудаас хоолой татах олон улсын томоохон төслүүд нь Хятад, Өмнөд Солонгос, Японы хэрэгцээг хангахаас гадна бүс нутгийн интеграцийн үйл явцыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Саяхан Шанхайд болсон АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр ОХУ-ын ерөнхийлөгч Путин тавьсан илтгэлдээ бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд эдгээр төслүүд чухал болохыг дурьдаад энэ асуудлыг шийдвэрлэхэд бүс нутгийн орнууд түүний дотор ОХУ гол үүрэг гүйцэтгэх тухай цохон тэмдэглэсэн юм. Мөн ОХУ, БНХАУ-ын хооронд “Орос-Хятад” гэсэн 2.4 мян.км нефть дамжуулах хоолойн төслийг 2005 он хүртэл барьж байгуулахаар тохиролцлоо. Энэ төслөөр Хятадад жил бүр 20-30 сая тонн нефть нийлүүлэгдэх болно.

Ийнхүү ЗХА-ийн бүс нутагт хэрэгжүүлж болох олон улсын томоохон төслүүдээс 1991 оноос НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн Түмэн голын сав газрыг хөгжүүлэх буюу 20 жилд 30 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийж цоо шинэ хөгжлийн бүс байгуулах ажлыг ЗХА-ийн интеграцийн бодит эхлэл гэж үзэх болсон билээ. Тиймээс 10-аад жилийн өмнө гараагаа эхэлсэн энэ төслийн хэрэгжилт, түүний ололт, бэрхшээлтэй талуудыг энд бас дурьдах нь зүйтэй байх.

10 жилийн хугацаанд Түмэн голын сав газарт БНСУ, Тайланд, Япон, АНУ, Зүүн Өмнөд Азийн орнуудаас оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1.5 тэрбум ам.долларт хүрсэн байна. Мөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 8 сая ам. доллар, дэлхийн хүрээлэн байгаа орчныг хамгаалах байгууллагаас 5 сая ам. долларын хөрөнгө оруулж төсөл хэрэгжүүлж байна. Эдгээр хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 520 сая нь БНХАУ-ын Жилин мужийн Янбины тойрогт, 535 сая нь ОХУ-ын Алс дорнодын Приморийн хязгаарт тус тус орсон байна.

Ер нь Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төслийг хамрах хүрээгээр нь авч үзэн эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүдийг нь Янбины тойрог, БНХАУ /Жилин муж/, Приморийн хязгаар /ОХУ, Алс дорнод/, Ражин-Сонбоны чөлөөт бүс /БНАСАУ/-ээр харуулж байгаа боловч Монголын дорнод хэсгийн хувьд биеэ даасан иж бүрэн үзүүлэлтүүдийг харуулах боломжгүйгээс улсын хэмжээгээр авч харуулж байна.

	Хүн ам (000)	Гол хотууд	Газар нутгийн хэмжээ (км 2)	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая.ам.доллар) 1991-2000
Янбины тойрог, БНХАУ Жилин муж	2.186	Янжи	42.700	519
Ражин Сонбон, БНАСАУ	150	Ражин	746	88
Монголын дорнод хэсэг	223	Чойбалсан	287.500	356
Приморийн хязгаар, ОХУ	2.200	Владивосток	165.900	535
Бүгд	4.759		496.846	1.498

- Монголыг бүхэлд нь авч үзэв. Эхийг A Brief Introduction to Tumen, 2000

Түмэн голын сав газарт эдийн засгийн хоцрогдлыг даван туулах улс орнуудын нийгэм - эдийн засгийн хөгжилд дэм өгөх зорилгоор зам, тээвэр, харилцаа холбоо, худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, байгаль орчныг хамгаалах зэрэг чиглэлээр 10 гаруй салбар төсөл боловсруулаад ажиллаж байна. Эдгээр төслүүдийн дотор Монгол улсын

эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх Монголын Дорнод аймгийн Чойбалсан хот, Хятадын ӨМӨЗО-ны Рашаант өртөөг холбосон 500 км орчим төмөр зам тавих төсөл яригдаж байгаа юм. Энэ төсөлд нийтдээ 500 сая ам.доллар, үүнээс төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад 350.000 ам.доллар шаардлагатай байна. Энэ төсөл хэрэгжсэнээр Монгол улс Хятадын Рашаант, Чанчуны (Жилин муж) өртөөгөөр дамжин Түмэн голын сав газрын далайн боомтод хүрэх бололцоотой болох юм. Өнөөдөртөө эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй байгаа ч Түмэн голын хөгжлийн хөтөлбөрийн нарийн бичгийн дарга нарын газар, гишүүн орнуудын хамт шийдвэрлэх арга замыг хайж байна. Үүний дотор ЗХА-ийн хөгжлийн банк (NADB), ЗХА-ийн Түмэн голын сав газрын хөрөнгө оруулалтын корпораци (NEATIC) байгуулах асуудлыг эрчимтэй тавьж байгаа билээ.

Ер нь энэ бүс нутгийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар эрдэмтэд судлаачид олон янзын санаа дэвшүүлж байдаг юм.

ЗХА-ийн эдийн засгийн интеграцийн хүрээнд Түмэн голын сав газрын дэд бүтцийг нээн хөгжүүлэхэд даруй 20 тэрбум ам. доллар хэрэгтэй гэж энэ оны 11-р сард Японы Хокурику хотод болсон ЗХА-ийн эдийн засгийн хуралдаан дээр яригдлаа.

Мөн Хавайн арлын Дорно-Өрнө төвийн доктор Станли Каццугийн тооцоолсноор жилд 7.5 тэрбум ам.доллар шаардлагатай байгаа бөгөөд энэ нөхцлийг хангах бололцоо гэвэл ОУ-ын санхүүгийн байгууллага, улс хоорондын засгийн газрын тусламж, хувийн хөрөнгө оруулалт зэргээс жилд 2.5 тэрбум доллар, ЗХА-ийн хөгжлийн банк байгуулах замаар 5 тэрбумыг тус тус олохоор тооцоолсон байна.

Ийнхүү ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Түмэн гол төслийн хүрээнд багагүй хөрөнгө оруулалт хийгдэж бүтээн байгуулалт явагдаж байгаа ч өнөө үед дэлхий дахинаа эрчимтэй өрнөж байгаа глобалчлал, интеграцчиллын нөхцөлд уг төслийн хэрэгжилт удаашралтай байгаагаас үүдээд энэ бүс нутгийн олон талт хамтын ажиллагаа, интеграцийн үйл явц, цаашдын өрнөлтийн талаар судлаачийн хувьд санаа бодлоо хэлье гэж бодож байна.

ЗХА-ийн бүс нутаг нь өөрийн нөөц боломжоороо Ази, Номхон далайн бүс нутагт төдийгүй дэлхийн улс төр, эдийн засагт жинтэй үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой бүс нутаг юм. Юуны өмнө ЗХА-ийн интеграци хөгжихөд улс төр, эдийн засгийн харилцан хамаарал бүхий хоёр тал байгааг бодолцох хэрэгтэй. ЗХА-ийн эдийн засгийн интеграцийн хөгжлийг улс төрийн асуудлаас нь ангид авч үзэх боломжгүй юм. Гэтэл өнөөдрийн тухайд энэ нөхцөл хараахан бүрдээгүй бөгөөд үүнд олон хүчин зүйлүүд нөлөөлж байна.

1. Улс төрийн аюулгүй байдлын талаар тогтворгүй байна.

- Япон БНАСАУ-ын харилцаа сэргээгүй байна.
- Япон, ОХУ-ийн хооронд энхийн гэрээ байгуулагдаагүй байна.
- Бүс нутгийн ихэнх орнуудын хооронд газар нутгийн маргаан буй гэх мэт.

2. Бүс нутгийн орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин жигд бүс байна.

Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдхүүний үзүүлэлт (ам. доллараар):

- Ляонин	1225
- Жилин	756
- Хэйлонжан	921
- Тэнжин	1820
- Өвөр Монгол	647
- Бээжин	2079
- Монгол	400
- ОХУ-ын Алс дорнод	2500
- Хойд Солонгос	200
- Өмнөд Солонгос	8679
- Япон	34428

3. Интеграцийн үйл явц эрчимтэй хөгжих гол нөхцөл болох гадаадын хөрөнгө оруулалтын орчин бүрдээгүй байна.

Интеграцийн үйл явц эрчимтэй хөгжих гол нөхцөл нь гадаадын хөрөнгө оруулалт орох таатай орчин нөхцлийг бүрдүүлсэн байх нь ойлгомжтой билээ. Өнөөдрийн байдлаар ЗХА-ийн орнуудад гадаадын хөрөнгө оруулалт дорвитой орохгүй байгаа бөгөөд үүний шалтгааныг дараахи үндсэн зүйлээр тайлбарлаж болох байна. Үүнд:

а) БНАСАУ-д төрийн удирдлагын хуучин дэглэм хэвээр ноёрхож, цэрэг, улс төрийн төвлөрсөн хатуу бодлого явуулж байгаа;

б) Орос оронд нийгэм-эдийн засгийн тогтвортой бүс байдал үргэлжилж байгаа;

в) Бүс нутгийн орнуудын хооронд харилцан итгэлцэл хараахан бүрэлдэж тогтоогүй;

г) Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцогч орнуудын ашиг сонирхол нэдмэл байр суурьтай болж чадаагүй байна.

Энд ЗХА-ийн бүс нутгийн орнуудын засгийн газрын хэмжээнд яригдаж байгаа ганцхан төсөл болох Түмэн голын төсөлд Япон улс оролцоогүй гадна үлдсэн хэвээр байгааг дурьдаж болно.

Үүнээс үүдэн ЗХА-ийг жинхэнэ утгаар нь ХХI зууны их бүтээн байгуулалтын талбар, дэлхийн хөгжлийн нэгэн шинэ төв болгон төлөвшүүлэхэд бүс нутгийн орнууд одооноос маш эрчимтэй ажиллах шаардлагатай болж байна.

Бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлыг ЗХА-ийн орнуудын засгийн газрын түвшинд ярих улс төрийн хэлэлцээний механизмтай болох, үүнд: а) Солонгосын хойгийн асуудлаар хэлэлцээг сэргээх; б) Хоёр Солонгосын хэлэлцээр; в) АПЕК-ийн бүсийн чуулга, АРФ; г) АСЕАН-ы дээд хэмжээний уулзалт зэргийг ашиглаж болох юм.

"Түмэн гол" төслийг жинхэнэ ЗХА-ийн орнуудын хамтын ажиллагаа, интеграцийн талбар болгохын тулд: **нэгдүгээрт:** хамаарч буй газар нутгийг тэлэх; **хоёрдугаарт:** санхүү, техник, технологийн өндөр чадавхи бүхий Япон мэтийн бусад орноор оролцогчдын тоог нэмэгдүүлэн тэдний сонирхолд нийцсэн асуудлыг төсөлд нэмэн тусгах, **гуравдугаарт:** төслийн хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий банк болон санхүүгийн байгууллага байгуулах, **дөрөвдүгээрт:** ЗХА-ийн орнуудын засгийн газар хоорондын байгууллага байгуулан түүнд "Түмэн гол"-ын төсөл болон бүс нутгийн хөгжил, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаатай холбогдсон хөрөнгө оруулалт, гааль, татвар, хөнгөлөлт, ажиллах хүчний гэх мэт бодлогын асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг чиглэлээр ажиллуулах шаардлагатай байна.

ERINA-ийн ЗХА-ийн эдийн засгийн бага хурал, EAST WEST CENTER-ийн эдийн засгийн форум, UNDP-ийн Түмэн гол төслийн нарийн бичгийн дарга нарын газар болон бусад байгууллагаас сүүлийн 10 жилийн дотор дэвшүүлж ирсэн олон тооны санаа санаачилгуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлэх арга замыг боловсруулах, ЗХА-ийн орнуудын засгийн газрын экспертүүдийн зөвлөл байгуулах;

Дэд бүтцийн өргөн сүлжээ бий болгох, тэдгээрийг санхүүжүүлэх ЗХА-ийн хөгжлийн банк, ЗХА-ийн хөрөнгө оруулалтын корпораци байгуулах санал гарч байгааг дэмжиж, яаралтай хэрэгжүүлэх;

ЗХА-ийн бүс нутгийн орнуудын хооронд соёл урлаг, спорт, байгаль орчин, хот, мужийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал байна.

Монгол улс ЗХА-ийн бүс нутгийн интеграцийн үйл явцад идэвхтэй оролцох үүднээс улс төр, эдийн засгийн хүрээнд тавигдаж байгаа эдгээр санал санаачилгыг хэрэгжүүлэхэд зохион байгуулагч, идэвхтэй дэмжигч байхаас гадна бүс нутгийн интеграцид орох эдийн засгийн үндэсний загварыг боловсруулан ажиллах нь зүйтэй гэж бодож байна.

ЗХА-ийн орнуудын хооронд харилцаа, хамтын ажиллагаа ихээхэн идэвхжиж, үүний үр дүнд улс орон тус бүр олон улсын хөдөлмөрийн хуваарийн үр шимийг улам бүр ихээр хүртэх боломжтой болох бизээ.

The article is about enhancing integration process which is occurring in the Asia Pacific region. The author is emphasizing importance of Mongolia's involvement in the process, especially in bilateral and multilateral relations in the North East Asian sub region. Specifics and comparative advantages of the sub region are described which would enable countries located in it to implement various projects for their future development. The great potentials of cooperation are described beside main obstacle of the Korean peninsula issues.